# ГАРЧИГ


1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ..........4
   1.1 Төслийн ерөнхий мэдээлэл ..........4
      1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл..........4
      1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт ..........4
      1.1.3 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт ..........6
   1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт ..........7
      1.2.1 Ордын геологийн нөөц..........7
      1.2.2 Ил уурхайн олборлолт ..........9
      1.2.3 Ил уурхайн ажиллах горим ..........10
      1.2.4 Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө..........10
      1.2.5 Баяжуулах технологи ..........11
      1.2.6 Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал..........12
      1.2.7 Баяжуулах хэсгийн бүтээгдэхүүн гаргалтын тооцоо ..........12
   1.3 Дэд бүтэц ..........13
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..........15
   2.1 Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга ..........15
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ..........20
   3.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .......... **Error! Bookmark not defined.**
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ..........22
   4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ..........24
   4.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ..........30
   4.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..........31
   4.4 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ..........33
   4.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ..........35
   4.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ..........37
   4.7 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..........41
   4.8 ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ..........43

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. MV-023040 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд ....................................5
Хүснэгт 2. Уурхайн ажилчдын тоо ........................................................................................7
Хүснэгт 3. Ордын батлагдсан геологийн нөөц ........................................................................8
Хүснэгт 4. Ил уурхайн хэмжээсүүд ......................................................................................10
Хүснэгт 5. Уурхайн ажлын горим..........................................................................................10
Хүснэгт 6. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө........... **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 7. Баяжуулах хэсгийн горим ..................................................................................12
Хүснэгт 8. Баяжуулах хэсгийн бүтээгдэхүүн болон хаягдал гаргалтын тооцоо ..................12
Хүснэгт 9. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ...............20
Хүснэгт 10. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал .22
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ............24
Хүснэгт 12. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө ......... **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 13. Нөлөөлөлд өртсөн талбайн эрчим......................... **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 14. Экосистемийн нөлөөллийн эрчим......................... **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 15. Амьдрах орчны нөлөөллийн эрчим ..................... **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 16. Ландшафтын нөхцөл ............................................ **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 17. Ландшафтын байршлын нөлөөлөл....................... **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 18. Төслийн үргэлжлэх хугацаа................................. **Error! Bookmark not defined.**
Хүснэгт 19. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ..........................................................................................................................31
Хүснэгт 20. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....................................................33
Хүснэгт 21. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө..........................................................35
Хүснэгт 22. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ...........................................................37
Хүснэгт 23. Удирдлага  зохион байгуулалтын төлөвлөгөө ...................................................41
Хүснэгт 24. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь..............................................................................................................43

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг.....5
Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн ерөнхий зураг.....6
Зураг 3. Ордын алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн бүдүүвч.....11
Зураг 4. Нөлөөллийн тархалтын загвар.....**Error! Bookmark not defined.**
Зураг 5. Экосистемийн нөлөөлөл.....**Error! Bookmark not defined.**
Зураг 6. Амьдрах орчны нөлөөллийн эрчим.....**Error! Bookmark not defined.**
Зураг 7. Ландшафт нөлөөлөл.....**Error! Bookmark not defined.**
Зураг 8. Ландшафтын байршил.....**Error! Bookmark not defined.**
Зураг 9. Орчны мониторингийн цэгийн байршил.....40

# 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

### 1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл

| | |
|---|---|
| ***Төслийн нэр :*** | “Хуурай нуга, Нуга” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл |
| ***Төсөл хэрэгжүүлэгч :*** | “Алтайтаван мандал” ХХК,<br>Улсын бүртгэлийн дугаар: 9011065135<br>Регистрийн дугаар: 5120837<br>Хариуцлагын хэлбэр “Хязгаарлагдмал хариуцлагатай компани”<br>Тусгай зөвшөөрлийн дугаар : MV-023040 |
| ***Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:*** | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол, 14-225 тоот Утас: 976-99116233. |

**Үндсэн үйл ажиллагаа.** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол, 14-225 тоот Утас: 976-99116233.

**Ашигт малтмалын нөөцтэй холбоотой баримт бичгүүд.**

- Нөөц хүлээн авч, бүртгэх тухай АМГТГ-ын даргын 2025 оны 04-р сарын 04-ны өдрийн Н-29 тоот тушаал
- ЭБМЗ-ийн 2025 оны 02-р сарын 04-ний өдрийн хурлын ХХ-03-03 тоот дүгнэлт,

### 1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт

“Хуурай нуга, Нуга” нэртэй алтны шороон орд нь Төв аймгийн Жаргалант сумын Загдал багийн нутагт, Улаанбаатар хотоос баруун хойд зүгт 200 км, Жаргалант сумын төвөөс баруун хойд зүгт 45 км, Улаанбаатар-Дархан чиглэлийн төв засмал замаас баруун зүгт 50 км зайд "Хуурай нуга" нэртэй газар оршино. Ордын талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1:100000-ны масштабтай байрзүйн зургийн М-48-116 тоот хавтгайд оршино.




*Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг*

*Хүснэгт 1. MV-023040 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд*

| № | Өргөрөг (Longitude) | Уртраг (Latitude) |
|---|---|---|
| 1 | 105° 31' 29.5" | 48° 46' 34" |
| 2 | 105° 30' 1.15" | 48° 46' 34" |
| 3 | 105° 30' 1.15" | 48° 46' 17.58" |
| 4 | 105° 30' 17.76" | 48° 46' 17.58" |
| 5 | 105° 30' 17.76" | 48° 46' 15.14" |
| 6 | 105° 30' 1.15" | 48° 46' 15.14" |
| 7 | 105° 30' 1.15" | 48° 46' 1.87" |
| 8 | 105° 30' 12.14" | 48° 46' 1.87" |
| 9 | 105° 30' 12.14" | 48° 44' 47.31" |
| 10 | 105° 30' 12.15" | 48° 44' 47.31" |
| 11 | 105° 30' 12.15" | 48° 44' 47.31" |
| 12 | 105° 30' 36.63" | 48° 44' 47.31" |
| 13 | 105° 30' 36.65" | 48° 44' 14.88" |
| 14 | 105° 30' 36.65" | 48° 44' 14.88" |
| 15 | 105° 30' 36.65" | 48° 44' 14.87" |
| 16 | 105° 30' 36.66" | 48° 44' 14.87" |
| 17 | 105° 30' 36.66" | 48° 44' 14.87" |
| 18 | 105° 31' 0.48" | 48° 44' 14.87" |
| 19 | 105° 31' 1.13" | 48° 44' 14.87" |
| 20 | 105° 31' 1.13" | 48° 44' 4.76" |
| 21 | 105° 31' 5.52" | 48° 44' 4.76" |
| 22 | 105° 31' 5.52" | 48° 44' 2.86" |
| 23 | 105° 31' 1.13" | 48° 44' 2.86" |
| 24 | 105° 31' 1.13" | 48° 44' 1.86" |
| 25 | 105° 30' 1.25" | 48° 44' 1.86" |
| 26 | 105° 30' 1.25" | 48° 43' 31.87" |

| № | Өргөрөг (Longitude) | Уртраг (Latitude) |
|---|---|---|
| 27 | 105° 31' 41.15" | 48° 43' 31.87" |
| 28 | 105° 31' 41.15" | 48° 43' 51.88" |
| 29 | 105° 32' 29.83" | 48° 43' 51.88" |
| 30 | 105° 32' 29.83" | 48° 44' 4.46" |
| 31 | 105° 32' 34.2" | 48° 44' 4.46" |
| 32 | 105° 32' 34.2" | 48° 44' 17.56" |
| 33 | 105° 32' 32.91" | 48° 44' 17.56" |
| 34 | 105° 32' 32.91" | 48° 44' 27.84" |
| 35 | 105° 32' 30.6" | 48° 44' 27.84" |
| 36 | 105° 32' 30.6" | 48° 44' 34.2" |
| 37 | 105° 31' 35.25" | 48° 44' 34.2" |
| 38 | 105° 31' 35.25" | 48° 44' 35.91" |
| 39 | 105° 32' 30.6" | 48° 44' 35.91" |
| 40 | 105° 32' 30.6" | 48° 44' 38.38" |
| 41 | 105° 32' 28.55" | 48° 44' 38.38" |
| 42 | 105° 32' 28.55" | 48° 44' 45.57" |
| 43 | 105° 32' 26.49" | 48° 44' 45.57" |
| 44 | 105° 32' 26.49" | 48° 44' 51.48" |
| 45 | 105° 32' 15.44" | 48° 44' 51.48" |
| 46 | 105° 32' 15.44" | 48° 44' 55.9" |
| 47 | 105° 32' 15.44" | 48° 45' 11.79" |
| 48 | 105° 32' 46.28" | 48° 45' 11.79" |
| 49 | 105° 32' 46.28" | 48° 44' 58.42" |
| 50 | 105° 32' 51.93" | 48° 44' 58.42" |
| 51 | 105° 32' 51.93" | 48° 44' 42.49" |
| 52 | 105° 32' 56.3" | 48° 44' 42.49" |
| 53 | 105° 32' 56.3" | 48° |



*Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн ерөнхий зураг*

### 1.1.3 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт

**Төсөлд шаардлагатай хүний нөөц.** Тухайн байгууллагын үйл ажиллагааны амжилт нь нягт цэгцтэй удирдлага зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн бодлого, ажлын шуурхай шинжээс ихээхэн шалтгаална. “Алтай таван мандал” ХХК-ийн удирдлага,

Уурхайн дарга уурхайн үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг тодорхойлох, үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө, үндсэн үзүүлэлт, норматив, гүйцэтгэлийн тайлан, ашиг ба бүтээгдэхүүний хуваарилалт, орон тооны бүтэц, төсвийг батлах зэргээр ажиллана.

“Алтай таван мандал” ХХК-ийн "Хуурай нуга, Нуга" алтны шороон орд дээрх үйл ажиллагаа нь ил уурхай, элс угаан баяжуулах хэсэг гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

*Хүснэгт 2. Уурхайн ажилчдын тоо*

| № | Албан тушаал | Ажиллах орон тоо | | Ажиллах сар | |
|---|---|---|---|---|---|
| | | 1-р жил | 2-р жил | 1-р жил | 2-р жил |
| - | Захиргаа удирдлагын хэсэг | | | | |
| 1 | Уурхайн дарга | 1 | 1 | 12 | 4 |
| 2 | Ерөнхий инженер | 2 | 2 | 12 | 4 |
| 3 | Нягтлан бодогч | 2 | 2 | 12 | 4 |
| 4 | Маркшейдер инженер | 2 | 2 | 6 | 4 |
| 5 | ХАБЭА-н инженер | 4 | 4 | 6 | 4 |
| 6 | Байгаль орчны мэргэжилтэн | 2 | 2 | 6 | 4 |
| - | Дүн | 13 | 13 | - | - |
| - | Ил уурхайн хэсэг | | | | |
| 7 | Уулын мастер | 4 | 4 | 6 | 4 |
| 8 | Экскаваторын оператор | 8 | 8 | 6 | 4 |
| 9 | Автосамосвалын оператор | 16 | 16 | 6 | 4 |
| 10 | Бульдозерын оператор | 4 | 4 | 6 | 4 |
| 11 | Утгуурт ачигчийн оператор | 4 | 4 | 6 | 4 |
| - | Дүн | 36 | 36 | - | - |
| - | Элс угаан баяжуулах хэсэг | | | | |
| 12 | Баяжуулагч инженер | 4 | 4 | 6 | 4 |
| 13 | Сккруберын оператор | 4 | 4 | 6 | 4 |
| 14 | Гүйцээн баяжуулагч | 4 | 4 | 6 | 4 |
| 15 | Насосны оператор | 4 | 4 | 6 | 4 |
| 16 | Экскаваторын оператор | 4 | 4 | 6 | 4 |
| 17 | Утгуурт ачигчийн оператор | 4 | 4 | 6 | 4 |
| - | Дүн | 24 | 24 | - | - |
| - | Засвар, үйлчилгээний хэсэг | | | | |
| 18 | Засварчин, цахилгаанчин | 2 | 2 | 6 | 4 |
| 19 | Туслах ажилчин | 2 | 2 | 6 | 4 |
| - | Дүн | 4 | 4 | - | - |
| - | Аж ахуйн хэсэг | | | | |
| 20 | Хангамжийн нярав | 2 | 2 | 6 | 4 |
| 21 | Эмч, эрүүл ахуйч | 2 | 2 | 6 | 4 |
| 22 | Тогооч | 4 | 4 | 6 | 4 |
| 23 | Үйлчилгээний ажилчин | 4 | 4 | 6 | 4 |
| 24 | Үйлчилгээний машины жолооч | 2 | 2 | 6 | 4 |
| 25 | Харуул хамгаалалт | 4 | 4 | 12 | 4 |
| - | Дүн | 18 | 18 | - | - |
| - | Нийт дүн | 95 | 95 | - | - |

## 1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт

### 1.2.1 Ордын геологийн нөөц

Өнөөгийн мөрдөгдөж буй “Ашигт малтмалын нөөц, баялгийн ангилал”-ын зааврын дагуу “Хуурай нуга, Нуга” алтны шороон ордын алтны геологийн нөөцийг бодитой (B) болон боломжтой (C) зэрэглэлээр тооцсон байна.

“Хуурай нуга, Нуга” нэртэй алтны шороон ордод 2024 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд үндэслэн MV-023040 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөцийг

2025 оны 02-р сарын 04-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, УГА-ны даргын 2025 оны 04-р сарын 04-ний өдрийн Н/29 дугаартай тушаалын дагуу алтны нөөцийг Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

"Хуурай нуга, Нуга" ордын алтны геологийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 158.84 мян.м3 элсэнд шлихээр 50.39 кг, химийн цэврээр 44.05 кг, боломжтой (С) зэрэглэлээр 70.63 мян.м3 элсэнд шлихээр 20.90 кг, химийн цэврээр 18.30 кг, бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 229.47 мян.м3 элсэнд шлихээр 71.29 кг, химийн цэврээр 62.35 кг гэж тооцсон байна..

*Хүснэгт 3. Ордын батлагдсан геологийн нөөц*

| № | Хэсэглэлийн дугаар, нөөцийн зэрэглэл | Хөрсний зузаан, м | Элсний зузаан, м | Дундаж агуулга, мг/м$^3$ | Блокийн талбай, мян.м$^3$ | Хөрсний эзлэхүүн, мян.м$^3$ | Элсний эзлэхүүн, мян.м$^3$ | Алтны нөөц, (шлих), кг | Алтны нөөц, (цэвэр), кг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ПЛИОЦЕНЫ ОРД - ХУУРАЙ НУГА | | | | | | | | | |
| 1 | B1 | 3.00 | 1.30 | 111.71 | 8.47 | 25.41 | 11.01 | 1.23 | 1.07 |
| 2 | B2 | 2.00 | 1.00 | 213.33 | 3.75 | 7.50 | 3.75 | 0.80 | 0.70 |
| 3 | B3 | 4.20 | 1.60 | 323.71 | 4.46 | 18.73 | 7.14 | 2.31 | 2.01 |
| 4 | B4 | 5.30 | 1.03 | 233.43 | 11.62 | 61.59 | 11.95 | 2.79 | 2.42 |
| 5 | B5 | 6.33 | 0.75 | 321.72 | 12.93 | 81.89 | 9.70 | 3.12 | 2.71 |
| 6 | B6 | 6.53 | 1.05 | 536.37 | 7.28 | 47.56 | 7.64 | 4.10 | 3.56 |
| 7 | B7 | 6.80 | 0.68 | 422.50 | 10.72 | 72.90 | 7.29 | 3.08 | 2.68 |
| 8 | B8 | 7.73 | 0.57 | 356.82 | 15.40 | 119.09 | 8.80 | 3.14 | 2.73 |
| 9 | B9 | 7.93 | 0.80 | 445.75 | 10.60 | 84.09 | 8.48 | 3.78 | 3.28 |
| 10 | B10 | 5.60 | 0.80 | 396.25 | 6.94 | 38.86 | 5.55 | 2.20 | 1.91 |
| 11 | B11 | 4.64 | 0.72 | 394.74 | 8.55 | 39.67 | 6.16 | 2.43 | 2.11 |
| 12 | C1 | 4.00 | 1.60 | 105.32 | 5.40 | 21.60 | 8.64 | 0.91 | 0.79 |
| 13 | C2 | 3.40 | 1.40 | 176.23 | 9.16 | 31.14 | 12.82 | 2.26 | 1.96 |
| 14 | C3 | 3.60 | 2.00 | 444.85 | 1.36 | 4.90 | 2.72 | 1.21 | 1.05 |
| 15 | C4 | 4.20 | 1.80 | 279.85 | 2.68 | 11.26 | 4.82 | 1.35 | 1.17 |
| 16 | C5 | 5.07 | 0.67 | 478.91 | 4.73 | 23.97 | 3.15 | 1.51 | 1.31 |
| | Нийт (B) | 5.93 | 0.87 | 331.32 | 100.72 | 597.30 | 87.47 | 28.98 | 25.18 |
| | Нийт (C) | 3.98 | 1.38 | 225.12 | 23.33 | 92.86 | 32.16 | 7.24 | 6.29 |
| | Нийт (B+C) | 5.56 | 0.96 | 302.77 | 124.05 | 690.16 | 119.63 | 36.22 | 31.47 |
| ПЛИОЦЕНЫ ОРД - НУГА | | | | | | | | | |
| 1 | B12 | 8.20 | 0.90 | 546.51 | 8.60 | 70.52 | 7.74 | 4.23 | 3.73 |
| 2 | B13 | 4.17 | 0.96 | 151.89 | 11.00 | 45.83 | 10.56 | 1.60 | 1.41 |
| 3 | B14 | 6.48 | 0.85 | 358.31 | 18.40 | 119.29 | 15.64 | 5.60 | 4.94 |
| 4 | B15 | 6.48 | 0.76 | 271.86 | 25.70 | 166.62 | 19.53 | 5.31 | 4.68 |
| 5 | B16 | 5.00 | 0.72 | 340.50 | 15.50 | 77.50 | 11.16 | 3.80 | 3.35 |
| 6 | C6 | 8.40 | 0.80 | 233.74 | 1.23 | 10.33 | 0.98 | 0.23 | 0.20 |
| 7 | C7 | 5.33 | 1.07 | 168.05 | 5.30 | 28.27 | 5.65 | 0.95 | 0.84 |
| 8 | C8 | 8.00 | 0.93 | 635.43 | 4.30 | 34.40 | 4.01 | 2.55 | 2.25 |
| 9 | C9 | 3.00 | 0.80 | 122.24 | 3.17 | 9.51 | 2.54 | 0.31 | 0.27 |
| 10 | C10 | 6.00 | 1.20 | 393.23 | 3.20 | 19.20 | 3.84 | 1.51 | 1.33 |
| 11 | C11 | 7.00 | 0.40 | 1103.90 | 7.70 | 53.90 | 3.08 | 3.40 | 3.00 |
| 12 | C12 | 8.00 | 0.40 | 494.19 | 8.60 | 68.80 | 3.44 | 1.70 | 1.50 |
| 13 | C13 | 6.00 | 0.40 | 402.17 | 2.30 | 13.80 | 0.92 | 0.37 | 0.33 |
| - | Нийт (B) | 6.06 | 0.82 | 317.92 | 79.20 | 479.77 | 64.63 | 20.55 | 18.11 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| - | Нийт (C) | 6.65 | 0.68 | 450.42 | 35.80 | 238.21 | 24.47 | 11.02 | 9.71 |
| - | Нийт (B+C) | 6.24 | 0.77 | 354.31 | 115.00 | 717.98 | 89.10 | 31.57 | 27.82 |
| НИЙТ ПЛИОЦЕНЫ ОРД | | | | | | | | | |
| - | Нийт (B) | 5.99 | 0.85 | 325.63 | 179.92 | 1077.07 | 152.10 | 49.53 | 43.29 |
| - | Нийт (C) | 5.60 | 0.96 | 322.46 | 59.13 | 331.07 | 56.63 | 18.26 | 16.00 |
| - | Нийт (B+C) | 5.89 | 0.87 | 324.77 | 239.05 | 1408.14 | 208.73 | 67.79 | 59.30 |
| ДООД ПЛЕЙСТОЦЕНЫ ОРД | | | | | | | | | |
| 1 | B17 | 6.00 | 0.40 | 103.58 | 8.45 | 50.69 | 3.38 | 0.35 | 0.31 |
| 2 | B18 | 4.70 | 0.40 | 151.88 | 8.39 | 39.45 | 3.38 | 0.51 | 0.45 |
| 3 | C14 | 2.80 | 0.40 | 242.15 | 2.79 | 7.80 | 1.12 | 0.27 | 0.24 |
| 4 | C15 | 4.00 | 0.40 | 193.01 | 13.73 | 54.92 | 5.49 | 1.06 | 0.92 |
| 5 | C16 | 5.20 | 2.00 | 177.78 | 1.80 | 9.36 | 3.60 | 0.64 | 0.56 |
| 6 | C17 | 5.20 | 2.00 | 176.32 | 1.90 | 9.88 | 3.80 | 0.67 | 0.59 |
| - | Нийт (B) | 5.35 | 0.40 | 127.65 | 16.84 | 90.14 | 6.74 | 0.86 | 0.76 |
| - | Нийт (C) | 4.05 | 0.69 | 188.48 | 20.22 | 81.96 | 14.01 | 2.64 | 2.30 |
| - | Нийт (B+C) | 4.64 | 0.56 | 168.72 | 37.06 | 172.10 | 20.74 | 3.50 | 3.05 |
| НИЙТ ОРДЫН ХЭМЖЭЭНД | | | | | | | | | |
| - | Нийт (B) | 5.93 | 0.81 | 317.23 | 196.76 | 1167.21 | 158.84 | 50.39 | 44.05 |
| - | Нийт (C) | 5.21 | 0.89 | 295.89 | 79.35 | 413.03 | 70.63 | 20.90 | 18.30 |
| - | Нийт (B+C) | 5.72 | 0.83 | 310.66 | 276.11 | 1580.24 | 229.47 | 71.29 | 62.35 |

### 1.2.2 Ил уурхайн олборлолт

**Ордын уул-техникийн нөхцөл:** “Хуурай нуга, Нуга” нэртэй алтны шороон орд нь бага гүнтэй, олборлоход хялбар, дунджаар 0.311 гр/м3 агуулгатай, эдийн засгийн байршил сайн, зам харилцаа, дэд бүтэц сайн хөгжсөн, сүүлийн үед алтны олборлолт эрчимтэй явагдаж байгаа дүүрэгт хамаарагдана. Хайгуулын ажлын үр дүнгээр тус ордын хуулах шимт хөрсний дундаж зузаан 0.3 м, хөрсний дундаж зузаан 5.42 м, ашигт давхарга буюу алт агуулсан элсний дундаж зузаан 0.83 м, хөрс хуулалтын дундаж итгэлцүүр бага, бул чулуу, мөнх цэвдэгшил байхгүй, шаварлаг хэсгийн агуулга бага ба алттай давхаргын угаагдах чанар сайн зэрэг уул-техникийн таатай нөхцөлтэй юм.

**Ордыг ашиглах аргын сонголт:** Уул-геологийн нөхцөлд тохирох технологийг хэрэгжүүлж, зохион байгуулалтын хувьд ямар нэгэн бэрхшээлгүй ажиллах, эдийн засгийн үр өгөөжтэй байлгахад ашигт малтмалын ордыг ашиглах аргын сонголт чиглэнэ. Тус ордын хувьд ашигт малтмалын биет нь хэвтээ хэвгий уналтай, их биш зузаантай тул ил аргаар ашиглахаар тооцлоо.

**Ашиглалтын системийн сонголт, үндсэн үзүүлэлтүүд**

Ордын хувьд дунджаар 0.3 м зузаан шимт хөрс, 5.42 м зузаан хөрс, ургамлын үеэр хучигдсан, алт агуулсан элсний дундаж зузаан 0.83 м, уул-геологийн болон уул-техникийн ямар нэг хүндрэлгүй, ил аргаар олборлох боломжтой тул экскаватор болон автосамосвалын хослол бүхий тээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын систем хэрэглэн ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар сонголоо.

**Ашиглалтын системийн үндсэн үзүүлэлтүүд**

Авто тээвэр бүхий ил ашиглалтын системд доголын өндөр, оролын өргөн, мөргөцөг дэх ажлын талбайн өргөн, догол дахь фронтын урт гэсэн үндсэн хэмжээсүүд байна

*Хүснэгт 4. Ил уурхайн хэмжээсүүд*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоон утга |
|---|---|---|---|
| 1 | Элс олборлолтын доголын өндөр | М | 0.5-2.1 |
| 2 | Хөрс хуулалтын доголын өндөр | М | 5 |
| 3 | Доголын хажуугийн өнцөг | град | 55 |
| 4 | Авто замын өрген | М | 10 |
| 5 | Авто замын налуу | промилл | 80-100 |
| 6 | Элсний экскаваторын оролын өргөн | М | 16.5 |
| 7 | Хөрсний экскаваторын оролын өргөн | М | 17.8 |
| 8 | Хамгийн бага ажлын талбайн өргөн | М | 30 |

### 1.2.3 Ил уурхайн ажиллах горим

Уурхайн жилийн хүчин чадлыг төсөл захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаварт тусгасны дагуу ашиглалтын эхний жилд 40 кг, 2 дахь жилд 21.72 кг алт олборлохоор тооцсон.

Ил уурхайн уулын ажил нь улирлын чанартай явагдах бөгөөд ашиглалтын эхний жилд 05-р сарын 01-нээс 10-р сарын 31 хүртэл нийт 6 сар ажиллах ба 11-р сарын 01-нээс 04-р сарын 31 хүртэл буюу өвлийн улиралд сул зогсоно. Ашиглалтын 2 дахь жилд 05-р сарын 01-нээс 08-р сарын 31 хүртэл нийт 4 сар ажиллана.

*Хүснэгт 5. Уурхайн ажлын горим*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | |
|---|---|---|---|---|
| | | | 1-р жил | 2-р жил |
| 1 | Жилийн хуанлийн хоног | Хоног | 365 | 365 |
| 2 | Уурхайн жилд ажиллах хоног | Хоног | 184 | 123 |
| 3 | Цаг агаарын саатал | Хоног | 6 | 4 |
| 4 | Жилд ажиллах бодит хоног | Хоног | 178 | 119 |
| 5 | Хоногт ажиллах ээлжийн тоо | Ээлж | 2 | 2 |
| 6 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | Цаг | 12 | 12 |
| 7 | Цаг ашиглалтын итгэлцүүр | - | 0.88 | 0.88 |
| 8 | Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг | Цаг | 10.6 | 10.6 |
| 9 | Жилд ажиллах бодит цаг | Цаг | 3759.4 | 2513.3 |
| 10 | Цагийн хучин чадал | м3/цаг | 345.29 | 295.11 |
| 11 | Ээлжийн хучин чадал | м3/ээлж | 3646.30 | 3116.37 |
| 12 | Хоногийн хучин чадал | м3/хоног | 7292.60 | 6232.75 |
| 13 | Жилийн хучин чадал | мян.м3/жил | 1298.08 | 741.70 |

Уурхай нь хоногт 12 цагийн 2 ээлжээр ашиглалтын эхний жилд 178 хоног, 2 дахь жилд 119 хоног ажиллана. Уурхайн ажиллах горимд үндэслэн тооцоход ордыг ашиглах ил уурхайн олборлолтын цагийн хүчин чадал 295.11-345.29 м3/цаг, хоногийн хүчин чадал 6232.75-7292.60 м3/хоног байна

### 1.2.4 Уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

“Хуурай нуга, Нуга” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөт төсөл захиалагчийн ажлын даалгаварт тусгасан хүчин чадалд үндэслэн боловсруулсан болно. Ашиглалтын эхний жилд 178.60 мян.м3 алт агуулсан элс олборлох ашиглалтын 2 дахь жилд 81.23 мян.м3 алт агуулсан элс олборлоно. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөнд ашиглалтын жил тус бүрд хийгдэх шимт хөрс хуулалт, хөрс хуулалт болон алт агуулсан элс олборлолтын ажлын хэмжээг дэлгэрэнгүй тооцоолон дараах хүснэгтэд харууллаа.

*Хүснэгт 6. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө*

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | | | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-р жил | | | | 2-р жил | | | |
| | | | 5-6 сар | 7-8 сар | 9-10 сар | Нийт | 5-6 сар | 7-8 сар | Нийт | |
| 1 | Уулын цул | мян.$м^3$ | 270.88 | 466.37 | 560.84 | 1298.08 | 619.43 | 122.26 | 741.70 | 2039.78 |
| 2 | Херс хуулалт | мян. $м^3$ | 210.88 | 406.37 | 502.23 | 1119.48 | 559.43 | 101.03 | 660.46 | 1779.94 |
| 2.1 | Үүнээс: Шимт херс хуулалт | мян. $м^3$ | 15.69 | 18.58 | 20.59 | 54.86 | 22.56 | 5.98 | 28.53 | 83.40 |
| 2.2 | Үндсэн херс хуулалт | мян. $м^3$ | 195.19 | 387.79 | 481.64 | 1064.62 | 536.88 | 95.05 | 631.93 | 1696.55 |
| 3 | Элс олборлолт | мян. $м^3$ | 60.00 | 60.00 | 58.60 | 178.60 | 60.00 | 21.23 | 81.23 | 259.84 |
| 4 | Дундаж агуулга | гр/ $м^3$ | 0.168 | 0.260 | 0.342 | 0.256 | 0.363 | 0.144 | 0.306 | 0.272 |
| 5 | Алт (Шлихээр) | кг | 10.08 | 15.60 | 20.07 | 45.74 | 21.77 | 3.06 | 24.83 | 70.58 |
| 6 | Алт (Цэврээр) | кг | 8.82 | 13.64 | 17.55 | 40.00 | 19.04 | 2.67 | 21.72 | 61.72 |
| 7 | Херс хуулалтын дундаж итгэлцүүр | $м^{3/}$ $м^3$ | 3.51 | 6.77 | 8.57 | 6.27 | 9.32 | 4.76 | 8.13 | 6.85 |
| 8 | Олборлолтод ертех талбай | мян.$м^2$ | 52.31 | 61.94 | 68.62 | 182.87 | 75.19 | 19.93 | 95.11 | 277.98 |
| 9 | Олборлолтод ертех талбай | га | 5.23 | 6.19 | 6.86 | 18.29 | 7.52 | 1.99 | 9.51 | 27.80 |

## 1.3 Баяжуулах технологи

Алт агуулсан элсийг СБ-100 маркийн угаах төхөөрөмж буюу скрубберээр ангилж, -20 мм ангиллын бүтээгдэхүүнийг ГДШ маркийн хоригт цорго буюу гүн дүүргэлтийн шлюзээр баяжуулах ба гүйцээн баяжуулалтанд СКО-2 маркийн сэгсрэх ширээ ашиглана.




*Зураг 3. Ордын алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн бүдүүвч*

### 1.3.1 Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал

Баяжуулах хэсэг нь элс олборлох ажлыг дагалдан улирлын чанартай явагдах бөгөөд эхний жилд 05-р сарын 01-нээс 10-р сарын 31 хүртэл нийт 6 сарын хугацаанд, 2 дахь жилд 05-р сарын 01-нээс 08-р сарын 31 хүртэл нийт 4 сарын хугацаанд ажиллана.

*Хүснэгт 7. Баяжуулах хэсгийн горим*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | |
|---|---|---|---|---|
| | | | 1-р жил | 2-р жил |
| 1 | Жилийн хуанлийн хоног | Хоног | 365 | 365 |
| 2 | Жилд ажиллах хоног | Хоног | 184 | 123 |
| 3 | Цаг агаарын саатал | Хоног | 6 | 4 |
| 4 | Жилд ажиллах бодит хоног | Хоног | 178 | 119 |
| 5 | Хоногт ажиллах ээлжийн тоо | Ээлж | 2 | 2 |
| 6 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | Цаг | 12 | 12 |
| 7 | Цаг ашиглалтын итгэлцүүр | - | 0.88 | 0.88 |
| 8 | Ээлжинд бүтээлтэй ажиллах цаг | Цаг | 10.6 | 10.6 |
| 9 | Жилд ажиллах бодит цаг | Цаг | 8031.4 | 2513.3 |
| 10 | Цагийн хүчин чадал | $М^3$/цаг | 22.24 | 32.32 |
| 11 | Ээлжийн хүчин чадал | $М^3$/ээлж | 234.83 | 341.32 |
| 12 | Хоногийн хүчин чадал | $М^3$/хоног | 469.67 | 682.63 |
| 13 | Жилийн хүчин чадал | мян.$м^3$/жил | 178.60 | 81.23 |

### 1.3.2 Баяжуулах хэсгийн бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Баяжуулах хэсэг нь уурхайгаас олборлосон элсийг гравитацийн аргаар баяжуулж 94.20%-ийн металл авалттайгаар ашиглалтын 2 жилийн хугацаанд нийт 58.14 кг цэвэр алт үйлдвэрлэн Монгол банканд тушаана.

*Хүснэгт 8. Баяжуулах хэсгийн бүтээгдэхүүн болон хаягдал гаргалтын тооцоо*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | | Нийт |
|---|---|---|---|---|---|
| | | | 1-р жил | 2-р жил | |
| | Баяжуулах элсний үзүүлэлтүүд | | | | |
| 1 | Угаан баяжуулах элсний хэмжээ | мян.$м^3$ | 178.60 | 81.23 | 259.84 |
| 2 | Элсэн дэх алтны агуулга | гр/$м^3$ | 0.256 | 0.306 | 0.272 |
| 3 | Элсэн дэх алтны хэмжээ (Шлихээр) | кг | 45.74 | 24.83 | 70.58 |
| | Бүтээгдэхүүн гаргалтын үзүүлэлтүүд | | | | |
| 4 | Баяжмалын гарц | % | 0.05 | 0.05 | 0.05 |
| 5 | Металл авалт | % | 94.20 | 94.20 | 94.20 |
| 6 | Баяжмал дахь алтны агуулга | гр/$м^3$ | 482.52 | 575.92 | 575.92 |
| 7 | Алтны хэмжээ (Шлихээр) | кг | 43.09 | 23.39 | 66.48 |
| 8 | Алтны хэмжээ (Цэврээр) | кг | 37.68 | 20.46 | 58.14 |
| | Хаягдал гаргалтын үзүүлэлтүүд | | | | |
| 9 | Хаягдлын гарц | % | 99.95 | 99.95 | 99.95 |
| 10 | Хаягдлын хэмжээ (Галь+Эфель) | мян.$м^3$ | 178.51 | 81.19 | 259.71 |
| - | Галь гаргалт | мян.$м^3$ | 43.97 | 20.00 | 63.97 |
| - | Эфель гаргалт | мян.$м^3$ | 134.54 | 61.19 | 195.73 |
| 11 | Хаягдал дахь алт алдалт | % | 5.80 | 5.80 | 5.80 |
| 12 | Хаягдал дахь алтны агуулга | гр/$м^3$ | 0.015 | 0.018 | 0.016 |
| 13 | Хаягдал дахь алтны хэмжээ | кг | 2.65 | 1.44 | 4.09 |

## 1.4 Дэд бүтэц

<table>
<tr>
<td>Уурхайн тосгон, барилга байгууламж</td>
<td>Төслийн хугацаанд тур барилга байгууламжуудыг барьж ашиглах бөгөөд эдгээр барилгууд нь тоноглосон сэндвичэн барилгууд байна.<br>Уурхайн бүрэлдэхүүнд:<br>➢ Алт агуулсан элс олборлох ил уурхай, шимт хөрсний тур овоолго<br>➢ Элс угаан баяжуулах хэсэг түүний дэргэдэх бүтээгдэхүүний овоолго<br>➢ Эргэлтийн усан сангийн байгууламж<br>➢ Уурхайн ажилчдын кемп<br>➢ Уурхай орчмын замууд зэрэг объектууд багтана.<br><br>Засварын талбайг хотхоны баруун хойд хэсэгт 0.3 га талбайд байгуулна. Талбайд сэлбэг, материалын агуулах, шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг байрлуулна. Засварын талбайн дэргэд түр шатахуун түгээгүүрийг байрлуулсан.<br>Уурхайн ажилчдын амрах байр нь тус бур 3x6 м хэмжээтэй 5 ш, сэлбэг, материалын агуулах нь 3x6 м хэмжээтэй 1 ш, уурхайн оффис нь 4x7 м хэмжээтэй 1 ш, гал тогоо болон хоолны газар нь 12x3 м хэмжээтэй 1 ш тоноглосон сууц байна.<br><br><br>Эргэлтийн усан сан нь 2 тунаах нуур, 1 цэврийн нуураас бүрдэх ба цэврийн нуураас технологийн усаа татаж ашиглана. Нуурын багтаамжийг тооцохдоо баяжуулалтын технологийн хэрэгцээт усыг багтаах хэмжээтэй байхаар төлөвлөсөн.<br>Баяжуулалтын технологийн хэрэгцээт ус нь 109.64 м3/цаг бөгөөд хоногийн хэрэгцээт ус 2631.43 м3 байна. Тунаах нуурын гун 3 м, тунаах нуурын талбай 890 м2 байна.</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td>
</td></tr>
<tr><td>Цахилгаан хангамж</td><td>Уурхайн нийт цахилгааны хэрэглээг “Алтай таван мандал” ХХК-ийн эзэмшлийн 150 кВт-ын 1 ш, 50 кВт-ын 2 ш дизель генератораар хангахаар төлөвлөсөн.<br><br>Ажилчдын хотхон, уурхайн хангамжийн байр, цайны газар, уурхайн дүүргэлтийн станцын хяналтын байр, ус дамжуулах насос, трансформаторын байр, уурхайн бус зэрэгт голчлон цахилгаан бага зарцуулдаг бүдэг гэрлийн төхөөрөмж суурилуулна. Үйлдвэр, операторын байр, бутлуурын байр, туузан конвейерын галерей зэрэгт өндөр хучин чадалтай галогенид гэрэл, бусад хэсэгт шорооны хамгаалалттай гэрлийг суурилуулна.</td></tr>
<tr><td>Усан хангамж</td><td>“Хуурай нуга, Нуга” алтны шороон ордын ил уурхайн төсөл нь 2 жилийн хугацаанд хэрэгжинэ. Уурхайд тоос дарах зорилгоор зам усалгаанд болон унд, ахуйн зориулалтаар ус ашиглана. Унд ахуйн усны хэрэглээ болон зам усалгаа, нөхөн сэргээлт, баяжуулалтад ашиглах усны хэрэглээг гүний усаар хангана.</td></tr>
</table>

# 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1 Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

### Газрын гадарга, хэвлий.

Монгол улсын физик газар зүйн байрлалаар ойт хээрийн ба тал хээрийн бүсүүдийн шилжилтийн бүсэд хамаардаг. Талбайн дотор байнгын урсгал устай гол горхи байхгүй боловч Загдал гол талбайн урд талаар урсан өнгөрдөг. Хайгуулын хэрчигдэлтэй, дунд зэргийн харьцангуй өндөртэй уул, толгодууд бий. Томоохон хөндийнүүд нь U хэлбэртэй, дунд зэргийн хөндий ба жижиг жалгууд нь V маягийн хэлбэртэй байна.

Сумын эдэлбэр нутаг нь дунджаар д.т.д 1050 м өндөрт өргөгдсөн байна. Нийт сумын нутаг дэвсгэрийн 74.9 хувийг 800-1200 м, 25.1 хувь нь 1200 м-ээс дээш өндөрт өргөгдсөн байна.

Тус судалгааны талбай нь далайн түвшнээс дээш 1142-1220 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан байна. Харин газрын гадаргын хэвгий буюу налуу 12.2-30.6 (градус)-т байна.

### Уур амьсгал.

Жаргалант сумын нутагт 2012-2021 оны хооронд дунджаар агаарын температур -1.6...+1.2°C-ын хооронд хэлбэлзсэн бөгөөд өвлийн улиралд -21.7...-17.7°C, хаврын улиралд -5.4...+10.4°C, зуны улиралд +16.4...+19.0°C харин намрын улиралд -9.9...+10.1°C хүрсэн байна. Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр 208.8...388.9 мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өвлийн улиралд 1.9...3.6 мм, хаврын улиралд 3.7...23.1 мм, зуны улиралд 57.4…88.1 мм, намрын улиралд 7.2...39.2 мм-ийн хооронд унадаг. Энэ бүс нутагт хамгийн их хур тунадас 8 сард дунджаар 88.1 мм, хамгийн бага хур тунадас 2 сард дунджаар 1.9 мм орчим ордог байна.

Харьцангуй чийгшлийн жилийн явцыг 2012-2021 оны дундаж утгаар 4-р зургаас үзвэл, хамгийн их утга нь өвлийн улиралд 77%, дараагийнх нь зуны улиралд 70% хүрч тус тус ажиглагдана. Харин хамгийн бага их утга нь хаврын улиралд 46%, дараагийнх нь намрын улиралд 60% хүрч тус тус тохиолдоно. Эндээс үзвэл өвлийн хахир хүйтэн үе болон зуны хур тунадасны хэмжээнээс шалтгаалан агаарын чийгшил нэмэгддэг бол хавар, намрын улиралд дулааны өсөлт түргэн бөгөөд хөрсний нөөц чийг дутмаг байх учир агаар ихээхэн хуурай болдог нь харагдана.

Судалгааны талбайн нутагт салхины давтагдал жилийн 4 улирлын турш хойд зүгээс 18-28%, өмнө зүгээс 11-20% зонхилно.

### Агаарын чанар.

Уурхайн бүсэд PM 2.5 ширхэглэгтэй тоосны нягтшил 15-аас 28 мкг/м3, PM 10 ширхэглэгтэй тоосны нягтшил 25-аас 42 гр/м3 байгаа нь Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2025) стандартын хүлцэх агууламжаас нэн бага байна.

Дээрх үр дүнгээс үзэхэд гадаад орчны агаар дахь тоосонцрын хэмжээ “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2025” стандартад заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Төслийн талбай дотор авсан дуу шуугианы хэмжээ мөн адил дБА байгаа нь MNS 4585:2025 Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна. Эндээс үзвэл төслийн талбай орчны бүс нутаг газар ашиглалтын байдлаасаа шалтгаалан дуу чимээний түвшин ихсэж багасах нөхцөл байна.

**Геологийн тогтоц ба геоморфологи.**

Тус 2 орд нь баруун хойш 350 хэмээр сунасан нэр нэгт амнуудад байрлах ба хагарал, эвдрэлийн нөлөөгөөр үүссэн байна. Плиоцены цаг үед алтны шороон хуримтлал үүссэн ба дөрөвдөгчийн цаг үед плиоцены үед үүссэн хуримтлалыг дахин угааж дөрөвдөгчийн татмын шороон хуримтлал үүссэн байна. Алт агуулагч хурдас нь 10-20% шавар агуулсан шар, улбар-шаргал өнгийн сайн мөлгөржсөн хайрган худаст агуулагдана. Хайрга нь лимонит, марганцын ислээр бүрхэгдсэн байдаг.

Хуурай Нуга, Нуга амнуудын эртний голдирол нь өнөөгийн амны зүүн бортыг даган 1-6 м харьцангуй өндөр рельеф үүсгэн дэнж шиг харагддаг. Харагдах байдал нь дэнж шиг болович эртний плиоцены голдирол болно. Зүсэлтийн хамгийн гүн хэсгийг даган ерөнхийдөө зузаан, дунд-баян агуулга бүхий алтны давхарга тархах ба ховроор ул руугаа 80 см суудаг. Нуга амны плиоцены хурдас мөн амныхаа төв, зүүн хэсгийг даган 1-7 м өндөр геоморфологийн элемент үүсгэн тархдаг.

**Гадаргын болон газрын доор ус.**

Төв аймгийн Жаргалант сум нь ус зүйн хувьд Хойд мөсөн далайн ай савд багтах Хэнтийн нурууны баруун урд хажуугийн салбар уулсаас эх авах Баянгол нь Хараа голын эх бөгөөд  Сөгнөгөрийн голтой нийлж Хараа гол хэмээн нэрлэгдэнэ.

Хараа бол 5 дугаар эрэмбийн гол. Хэнтий нурууны баруун, баруун өмнөд хажуугийн салбар уулсаас эх авах Мандал гол, Баян, Сөгнөгөр голтой нийлж, Хараа гол хэмээн нэрлэгдэнэ. Ус хурах талбай 14388 км2, 353 м урт, 0.0040 хэвгий. Голдирлын дундаж өндөр 833 м, ус хагалбарын шугамын урт 945.6 км түүний дундаж өндөр 1711.0 голын сүлжээний нягт бага 0.26 км/км2 ус хурах талбайн дундаж өндөр 1272.0 м, хөндийн гүн дунджаар 878.0 м, ус хурах талбайн дундаж өргөн 40.8 км, сав газрын суналын зэрэг 8.6, ус хагалбарын шугамын тахиршлын зэрэг 2.2, хажуугийн хэрчигдэл 0.59, Хортон-Страхлерийн хуулиар голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.71 3.25 6.58 тус тус байна. Энэ голын савд 1 дүгээр эрэмбийн сайр-горхи 554, тэдгээрийн дундаж урт 2.7 км, ус хурах дундаж талбай 6.3 км2, 2 дугаар эрэмбийн горхи 140, 3 дугаар эрэмбийн гол 34,4 дүгээр эрэмбийн гол 8 байна. Хараа гол Баянбууралаас Түнхэл өнгөртөл нарийн хөндийгөөр урсах ба Зүүнхараагийн нутгаас эхлэн хөндий нь тавиурна. Голын ёроол элс-хайрган хурдастай. Хараа голын усны олон жилийн дундаж өнгөрөлт Сэлэнгэ аймгийн Баянгол сум орчимд 10.8м3/с байснаа Дархан хотоос доош 11.4 м3/с болно. Хамгийн их үер 1973 онд тохиож, их өнгөрөлт 722м3/с хүрч байна (Даваа., 2015).

Газрын доорх ус: Судалгааны талбайгаас гадагш өмнөд хэсэгт орших Зөөхийн гол нь маш их тахиралдсан, татам нь 1.8-4 км хүртэл өргөнтэй. Голдирлын өргөн 0.8-25 м, урсгалын хурд нь 1.2 м/сек байна.

Хайгуулын талбайн хэмжээнд гадаргуугийн тогтмол урсгал ус, гол байхгүй бөгөөд хур тунадаснаас хамааран түр зуурын урсгал голууд жижиг жалга, амуудаар байдаг. Тодруулбал Нуга, Шанаган амны голууд нь хур тунадас ихтэй жил урсдаг.

**Хөрсөн бүрхэвч.**

Судалгааны талбай нь нийт 1425 га газрыг хамрах бөгөөд талбайн хүрээнд нам уулын бэл хормой, жижиг ам хөндий бүхий гадарга нь гуу жалгын хэрчигдэл дунд зэрэг, уулс хоорондох нарийн хуурай сайрууд, тэгшивтэр хөндий зэрэг гадаргын олон янзын хэлбэрийг хамарч д.т.д 1070-1245м өндөрт байрлана. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Housekeeping Хархүрэн хөрсний дэд хэв шинжид багтах нимгэн, сайргархаг, нугархаг,

чулуурхаг төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна (Зураг 1, Хүснэгт 2). Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин дунд зэрэг, шимт үе давхарга нь зузаавтар (0-30 см), жижиг бөөмөрхөг болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд дунд зэрэг тэсвэртэй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж дунд зэрэг байдаг онцлогтой. Мөн сайргархаг, дунд ширхэгтэй тоосны агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн А-ВС-С гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзмагийн агууламж 1.3-2.7%, элсэрхэг биш хөрсний бүх үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 7.8-8.7 буюу дунд зэрэг шүлтлэг, хялбар уусах давсжилт маш бага буюу 0.17-0.30 dS/m байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд дунд ширхэгтэй тоосон фракц зонхилсон Элсэнцэр болон хөнгөн шавранцар бүрэлдэхүүнтэй. Нөлөөлөлд өртөөгүй ердийн хөрсний өнгөн үе давхарга дахь хортой болон био-идэвхт хүнд металлын агууламж стандартын хүлцэх агууламжаас ноцтой хэтэрсэн тохиолдол байхгүй хэвийн түвшинд байна.

**Ургамлан бүрхэвч.**

Төв аймгийн Жаргалант сумын нутагт дэвсгэрт хэрэгжих Загдал нэртэй алтны шороон ордыг ашиглах төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдлын хээрийн хэмжилт судалгааг 2025 оны 07-р сард хийж гүйцэтгэсэн. Төв аймгийн Жаргалант сумын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол Дагуурын уулын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Төслийн талбай орчимд нийт 24 овог, 47 төрөл, 60 зүйл  бүртгэв . Төслийн талбайд ургах боломжтой төрөл  зүйлийн тоо бүрхэц, нягтшил нь тухайн жилийн цаг агаарын онцлогоос ихээхэн хамааралтай байдаг учир тухайн жилийн онцлог хээрийн судалгааны цаг үеэс хамаарч ургамлын төрөл зүйлийн тоо бага зэрэг өөрчлөгдөж болно. Төслийн талбай дотор Монголын унаган ургамал Цагаан хунчир (Astragalus galactites Pall.) 1 зүйл, Монголд байгаа завсрын унаган ургамал Жижиг навчит харгана (Caragana microphylla (Pall) Lam.), Хурц навчинцарт ортууз (Oxytropis oxyphylla (Pall.) DC.), Шар хувиланги (Pedicularis flava Pall.) эртний цөлийн үлдэц унаган ургамал Дагуур хүж өвс (Haplophyllum dahuricum (L.) G. Don.) бүртгэгдсэн байна. Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө уулын хээрийн ургамалжилтай. Төслийн талбай 3 хэвшинжийн 2 хэвшил, 4 бүлгэмдэл тархдаг. Төслийн талбай бүхэлдээ MNS 5546:2005 стандартын ангиллаар их талхлагдсан ангилалд багтаж байна.  Төслийн талбай бүхэлдээ унаган бүлгэмдэл, судалгааны үед 7 сард гандуу бөгөөд ургамал ургалт эхлээгүй байсан. 2025 онд Монгол орны хэмжээнд төвийн бүсийн хойд хэсгээр ган тохиолдсонтой холбоотойгоор хуурайшилт явагдаж зүйлийн олон янз байдал ургац бага байна.

**Амьтны аймаг.**

Төсөл хэрэгжих талбай нь монгол орны байгалийн бүс бүслүүрийн мужлалаар Евразийн хээрийн мужийн Монгол-Дагуурын хээрийн тойрогт хамаарна.

**Тусгай хамгаалалттай газар нутаг.**

Төв аймагт нийт долоон ширхэг Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд байх ба үүнээс Жаргалант суманд Улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй байна. Төв аймгийн Жаргалант суманд нийт зургаан ширхэг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд байна. MV-023040 тоот тусгай зөвшөөрөлтэй ашиглалтын 1428.71 га талбай нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

**Түүх соёлын өв.**

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль-ийн 17.3-т Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн эрх зүйн хамгаалалтыг улсын, орон нутгийн, байгууллагын гэж ангилна. Улс орон нутгийн хамгаалалтад байх Түүх соёлын үл хөдлөхөд урсгалт зүйлийн жагсаалтыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно хэмээн заасан байдаг. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор уг жагсаалтыг шинэчлэн баталсан байна.

**Нийгэм эдийн засаг.**

Жаргалант сум нь 1927 онд “Сангийн тариалан” нэртэй байгуулагдан газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Засаг захиргааны нэгж 4 багтай.

Төв аймгийн баруун хойд хэсэгт, Улаанбаатар хотоос 72 км, аймгийн төвөөс 110 км зайд байрладаг. Улаанбаатар хот болон Төв аймгийн Батсүмбэр, Борнуур, Баянцогт сумтай хиллэдэг.

Жаргалант сумын хэмжээнд 2023 оны байдлаар 6479 хүн амьдарч байгаа ба өмнөх онуудтай харьцуулахад буурсан үзүүлэлтэй байна. Сумын хэмжээнд 2023 оны байдлаар 1967 өрх амьдарч байгаа ба 2021 онтой харьцуулбал өссөн үзүүлэлттэй байна.

Малын бүтэц 2023 оны жилийн эцсээр адуу 15.442 мян.толгой, үхэр 16.835 мян.толгой, хонь 75.826 мян.толгой, ямаа 43.186 мян.толгой, тэмээ 0 мян.толгой тус тус тоологдсон ба Жаргалант сумын хэмжээнд 151.442 мян.толгой мал тоологдсон байна.

**Төслөөс орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөлөл**

Төслөөс орон нутгийн хүн амд үзүүлэх нөлөөллийг ажил эрхлэлт, амьжиргаа, шилжин хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтийн хувьд авч үзлээ.

Алтны шороон ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр сумын түвшинд ажил эрхлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэж үүнийг дагаад иргэдийн амьжиргаанд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

**Төслөөс орон нутгийн эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл**

Тус төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт татвар болон хураамж хэлбэрээр улсын төсөвт төлнө. Төсөл хэрэгжсэнээр нөлөөллийн бүсийн сумын эдийн засагт дараах байдлаар шууд болон шууд бус эерэг нөлөөллүүд үзүүлнэ. Эдгээрт:

- Ажил эрхлэлт нэмэгдэх
- Уурхайд бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлснээр орлого нэмэгдэх, иргэдийн амьжиргаа сайжрах
- Сумын орлогын эх үүсвэр бэхжих
- Бизнес хөгжихөд таатай орчин бүрдэх

**Төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий нөлөөлөл**

Уурхайн нь шимт хөрсний овоолго, ил уурхай, технологийн зам, уурхайн тосгон, бусад дэд бүтцийн үйл ажиллагаанаас ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд аюулгүй байдалд тодорхой ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх дам нөлөөлөл

**Агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт**

- Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдах техникийн түлш шаталт, түлшний ууршилт зэргээс агаарыг бохирдуулагч бодис болон хүлэмжийн хийг ялгарах бөгөөд агаарын бохирдол болон уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж, дам байдлаар ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй.

- Уурхайн хөрс хуулалт, ачих, тээвэрлэх процессын үед агаарт их хэмжээний тоосжилт үүсэх ба аюулгүйн ажиллагааны дүрэм журмыг мөрдөж ажиллаагүй эсвэл хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангаагүйгээс ажилтан амьсгалын замын өвчлөлд өртөж болзошгүй.

**Ус, хөрсний бохирдол**

- Уурхайн үйл ажиллагааны улмаас шимт хөрсийг хамгаалдаг нимгэн давхарга үгүй болж хөрс бургих, тоосжилтыг ихээр нэмэгдүүлснээр амьсгалын замын өвчлөлд нөлөөлж болзошгүй.

Уурхайн засварын газрын үйл ажиллагаанаас бензин, дизель бусад шингэн хаягдал шүүрч ус болон хөрсний бохирдол үүсэж болзошгүй ба энэ үед ундны эх үүсвэр бохирдолд өртвөл ажилчдын эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлнэ.

**Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.**

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх ёстой учир сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ-д тусгагдаагүй, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, баримтлан тайлангаас тусад нь боловсруулж өгсөн болно.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг юм.

## 3.1 Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

